ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2026 оны 05 сарын 28 өдөр Дугаар 16/08 Арвайхээр сум

Зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын 2.9-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа энэхүү тогтоолын хавсралтад дурдсан 9 шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Монгол Улсын холбогдох хууль, журам болон өөрийн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах, дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх, жил бүрийн тогтоосон хугацаанд үйл ажиллагааны тайлангаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан ёсоор ирүүлж байхыг шашны байгууллагуудын тэргүүн нарт үүрэг болгосугай.

3. Хавсралтад заасан шашны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавин, холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдүүлж ажиллахыг Хяналтын ажлын хэсэг (С.Ундрах)-т даалгасугай.

ДАРГА Т.НАРАНГАРАВ

ИТХ/nuuts2026/1.togtool/togtool.doc

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16/08 дугаар тогтоолын хавсралт

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАСАН ШАШНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

Бат-Өлзий сум:

1. “Төвхөн” хийд
2. “Ганданравжаалин” хийд

Богд сум:

3. “Диваажингийн залбирал дацан” хийд

Есөнзүйл сум:

4. “Ганданчоймпэллин” хийд
5. “Дашгунгаадэжид” хийд

Зүүнбаян-Улаан сум:

6. “Хуйтангийн мөргөлийн өргөө” хийд

Өлзийт сум:

7. “Ганданлэгшад дашчойлон” хийд /яргайтын сүм /

Хархорин сум:

8. Эрдэнэзуу хийд
9. Эрдэнэ Зуугийн Цогчин хурал

---oOo---